



ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ
ТҮМЭН ШУВУУТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 18 өдөр

Дугаар Ж/01/2019

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг

зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Түмэн шувуут” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2019 оны 04 сарын 29-ний өдрийн 18.00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө-17, “Блю ской” зочид буудлын 3 давхар, “Даймонд” танхимд хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2019 оны 03 сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2019 оны 03 сарын 22-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2019 оны 04 сарын 06-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2019 оны 03 сарын 27-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ж.Болдод үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар “Түмэн шувуут” ХХК-ийн үүсгэн байгуулагч Л.Эрхэмбаярыг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
 - 7.1.1. Гүйцэтгэх захирал Ж.Болд
 - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
 - 7.2.1. Д.Наранцэцэг
 - 7.2.2. Б.Мөнгөнтуяа
 - 7.2.3. Б.Ундрах
8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

11.1. Хурлын тооллогын комиссын дарга:

11.1.1. Б.Урантунгалаг

11.2. Хурлын тооллогын комиссын гишүүд:

11.2.1. Ж.Уянга

11.2.2. Я.Оюунцэцэг

11.2.3. З.Өнөрсайхан

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ж.БОЛД

